



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/225

Булган сум

Гадаадад албан хэргээр ажиллуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам"-ыг тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Баасанжаргал, Хөгжимт жүжгийн театрын дарга Ж.Халиунаа, Нийгмийн даатгалын хэлтсийн тасгийн дарга Ж.Мичидмаа, Татварын хэлтсийн улсын байцаагч М.Бямбадорж нарыг 2023 оны 05 дугаар сарын 14-20-ны өдрүүдэд Канад улсад албан томилолтоор ажиллуулсугай.
2. Албан хэргээр ажиллах болсонтой холбогдуулан Гадаад харилцааны яамны Консулын газраас тус төлөөлөгчдөд гадаад албан паспорт хүссүгэй.
3. Албан хаагчдын гадаад албан паспортын хэрэглээнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ

